

БАКАЛАВРЫН ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ НИЙТЛЭГ АСУУЛТ БА ХАРИУЛТ

1. Танай сургуулийн эчнээ хөтөлбөрт суралцахаар сонирхож байгаа юм. Ерөнхий боловсролын сургууль төгссөн, Бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй бол энэ хөтөлбөрт суралцаж болох уу?

- Та өмнө нь их дээд сургуульд суралцаж, бакалаврын зэрэгтэй бөгөөд мэргэжил харгалзахгүй элсүүлдэг. Өөрөөр хэлбэл манай сургуулийн бакалаврын эчнээ хөтөлбөр нь 2 дахь мэргэжлээ эзэмших гэж буй хүмүүст зориулсан сургалт юм.

2. Танайх эчнээ хөтөлбөртөө ямар мэргэжлээр элсэлт авч, хэдэн жил сурч төгсгөдөг вэ?

-Нягтлан бодох бүртгэл

-Санхүү, банк

-Бизнесийн удирдлага хөтөлбөрүүд дээр 2 жилийн хугацаатай элсэлт авдаг.

3. Танай энэ эчнээ хөтөлбөрт яаж бүртгүүлэх вэ? Бүртгэлийн хураамж төлөх үү?

- Та цахимаар буюу <http://elselt.mandakh.mn/> хаягаар бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж 25000 төгрөгийг төлсөнөөр таны бүртгэл баталгаажихыг анхаараарай.

4. Энэ эчнээ хөтөлбөр хичээллэх өдрүүдийг тодорхой хэлж өгөөч?

- Бакалаврын эчнээ хөтөлбөрийн хичээл 8 сарын 31-нд эхлэж, 6-р сарыг дуустал хичээллэнэ. 7 хоног бүрийн бямба гарагт 09:00-19:30 хүртэл хичээллэнэ.

5. Сургалтын төлбөрөө хувааж төлөх боломжтой юу?

- Тиймээ, та сургалтын төлбөрөө хувааж төлөх боломжтой. Намар хичээл эхлэхээс өмнө нийт сургалтын төлбөрийн 50%-ийг, 2 сарын 01-ээс өмнө та үлдэгдэл төлбөрийг төлөх боломжтой.

6. Элсэлтийн шалгалт авдаг уу? Авдаг бол ямар чиглэлээр авах вэ? Шалгалтанд бэлдэх ном байдаг уу?

- Элсэлтийн шалгалт авдаг. Тус хөтөлбөрт суралцахаар бүртгүүлэгчдээс нийгэм, эдийн засаг, англи хэлээр таны сүүр мэдлэгийн түвшинг шалгах зорилгоор элсэлтийн шалгалт авдаг. Шалгалтанд бэлдэх ном байдаггүй.

7. Эчнээ хөтөлбөрт суралцаж буй оюутнуудад зориулсан хичээлээс гадна ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

- Эчнээ хөтөлбөрийн оюутнуудын дунд 2 төрөлт спортын тэмцээн, мөн мэргэжлийн хичээлийн мини олимпиад зохион байгуулдаг уламжлалтай.